БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 70 Номгон

"Хонгорын хүдэр" ХХК-ний хашаанаас
шлам ачихыг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 05-01-001/08 дугаартай актыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Хонгорын хүдэр" ХХК-д холбогдох хэрэг хяналтын шатны шүүхээр эцэслэгдэн шийдвэрлэгдэж орон нутгийн оролцооны хувь хэмжээг тогтоож талууд харилцан тохиролцох хүртэл тодорхойгүй хугацаагаар тус компаний хашаанаас шлам ачихыг хориглосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, зөвшөөрөлгүйгээр шлам ачиж тээвэрлэсэн холбогдох хүмүүсийг шалган тогтоож, олсон орлогыг орон нутгийн төсвийн орлогот төвлөрүүлэхийг аймгийн Цагдаагийн газрын дарга /Б.Оюутболд/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Лхагвасүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

116733

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 71 Номгон

Зарим хүмүүсийг шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн хурлын шагнал, түүнийг олгох журам"-ын 3.6 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж барилгын салбарт үр бүтээлтэй 38 жил ажилласан "Хөх бүрд" ХХК-ны засалчин Жадамбаагийн Цэцэгмаа, засалчин Сангидагвын Даваахорол, Богд сумын 1 дүгээр багийн малчин Батын Жавзантогоо, Баянхонгор сумын 5 дугаар багийн өндөр настан Пагамын Даваа, Галуут сумын 6 дугаар багийн өндөр настан Маанийн Пэрэнлэй, Тулга ХХК-ны засалчин Жүрэвийн Должин, Нэргүйн Заяа нарыг "Соёрхол" тэмдгээр, Эрдэнэцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч Доржийн Алтанцэцэг, Цэнд-Аюушийн Гомбо, Богд сумын 1 дүгээр багийн малчин Очирын Хүүхнээ, Адъяагийн Жаргал нарыг аймгийн ИТХ-ын шагнал "Хүндэтгэл"-ээр тус тус шагнасугай.

2. Шагналд зарцуулагдах 390000/Гурван зуун ерэн мянган/ төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Г.Ариунбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

115397

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 72 Номгон

Төрийн одон медалиар шагнуулах
хүмүүсийн тодорхойлолт өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Төрийн байгууллага, мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах нэр бүхий хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

1. Доржийн Пүрэвсүрэн — Баян-Овоо сумын малчин
2. Нансалын Чойжил — Баян-Овоо сумын өндөр настан
3. Бундын Лхагвасүрэн — Баян-Овоо сумын малчин
4. Батдуламын Ёндон — Баян-Овоо сумын малчин
5. Гончигийн Нямбуу — Богд сумын малчин
6. Суурийн Мөнхжаргал — "Баянхонгор-Эрчим хүч" ЦТ ХХК-ны ахмадын зөвлөлийн дарга
7. Цэдэвийн Баасан — Баялаг-Орд ХХК-ны авто ачигчийн операторч

"ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-ИАР

8. Төмөрийн Цамба — Баян-Овоо сумын малчин
9. Доржнамжаагийн Зоригт — Баян-Овоо сумын малчин
10. Бандихүүгийн Бямбасүрэн — Баян-Овоо сумын малчин
11. Готовын Мандах — Баян-Овоо сумын малчин
12. Банзрагчийн Маам — Баян-Овоо сумын малчин

115372

13. Бямбын Галдансамбуу — Баян-Овоо сумын малчин
14. Жигжидийн Дашцэрэн — Баян-Овоо сумын малчин
15. Дондогийн Жавзан — Баян-Овоо сумын малчин
16. Бямбын Данзан — Баян-Овоо сумын малчин
17. Бямбын Жамбал — Баян-Овоо сумын малчин
18. Дуламын Лхагваа — Баян-Овоо сумын өндөр настан
19. Чимэдийн Долгорсүрэн — Баян-Овоо сумын малчин
20. Жамцын Ёндонпил — Баян-Овоо сумын ЗДТГ-ын малын их эмч
21. Зундуйн Өлзийбат — Баян-Овоо сумын малчин
22. Ядамсүрэнгийн Мөнхзаяа — Баян-Овоо сумын малчин
23. Бат-Очирын Даваасүрэн — Баян-Овоо сумын өндөр настан
24. Дамдины Энхтуяа — Баян-Овоо сумын малчин
25. Дамдины Батжаргал — Баян-Овоо сумын малчин
26. Ядамжавын Төмөрсүх — Баян-Овоо сумын өндөр настан
27. Нацагийн Бат-эрдэнэ — Баян-Овоо сумын малчин
28. Жалбуугийн Бат-эрдэнэ — “Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК-ны монтёр
29. Очирхүү Эрдэнэбат — “Баялаг-Орд” ХХК-ны жолооч

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 73 Номгон

Хөрөнгийн тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам"-ын 1.6 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 37 дугаар, 57 дугаар тогтоолуудаар шийдвэрлэсэн автомашинуудын дуудлага худалдааг 2-3 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй тул хавсралтад заагдсан автомашинуудын худалдах доод үнийг 20 хувиар тус тус бууруулж дуудлагаар худалдсугай.

2. Автомашинуудын дуудлага худалдааг 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж орлогыг Төрийн сан банкин дах Орон нутгийн өмчийн албаны 030051009 тоот дансанд төвлөрүүлсүгэй.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2012 онд ашиглалтад орсон 8,0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 49-65 БНХ улсын дугаартай Ланд круйзер-80 автомашиныг аймгийн Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 57 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хүчингүйд тооцсугай.

5.Худалдсан, шилжүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

116001

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны
73 дугаар тогтоолын хавсралт

ҮНИЙГ БУУРУУЛАН ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /мян.км/	Дуудлагаар худалдах доод үнэ	Тайлбар
					сери	дугаар		арлын дугаар	моторын дугаар	моторын эзлэхүүн /см^3/			
1	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК	Универсаль-трактор 1.0	ЭО-2126	БНА	2076	2006-01-25	131335	6080223	6500	ажил лахгүй	800000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй
2	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК	Камаз Шланз 8.5	Стевр	УБВ	9180	2010-10-15	LZFH19M4210H03868	107095705	21000	610341	6800000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй
3	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК	Hundai 2009 ачааны машин 0.5	Хюндай	БНА	92-42	2009-08-25	ES415D2-2	D8AYP097645	13500	186700	400000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй
			Дүн									8000000.0	

_____оОо_____

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 74 Номгон

Өвөлжилтийн бэлтгэл хангах зарим
арга хэмжээний тухай

ТЭМДЭГЛЭХ НЬ:

Нийт нутгийн 20 орчим хувь нь өөрийн нутгийн бүх малаа өвөлжүүлэх боломж бага Баянхонгор, Баацагаан, Баянлиг, Баян-Овоо, Баян -Өндөр, Бөмбөгөр, Галуут, Жинст, Заг, Эрдэнэцогт сумдад хонин толгойд шилжүүлсэн малын тоо бэлчээрийн даацаас хэтэрсэн тул бусад сум, аймгийн нутагт отроор өвөлжүүлэх бэлтгэлийг эртнээс хийх шаардлагатай байна. Мал сүргийг эрсдлээс хамгаалах өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлт сумдад 24,7 хувь, аймгийн аюулгүйн нөөцөд 19 хувь байгаа нь малчдын түвшинд 4,2 хувьтай байгаа нь туйлын хангалтгүй байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал-д даалгах нь:

1.Хонин толгойд шилжүүлсэн малын тоо бэлчээрийн даацаас хэтэрсэн сумдад мал өвөлжиж, хаваржих нөхцөл хүндэрч болзошгүй тул малыг отроор өвөлжүүлэх, малыг эдийн засгийн эргэлтэд оруулж зах зээлд борлуулж малын тоог зохистой түвшинд хүргэх, нэмэлт тэжээл бэлтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авсугай.

2. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор малчин өрх бүр хонин толгойд шилжүүлсэн мал тутамд 10 кг-аар тооцож аюулгүйн нөөц бүрдүүлсүгэй.

3. Хилийн зурвас газар, Тусгай хамгаалалттай болон аймаг дундын отрын бүс нутаг, бусад сумдад мал өвөлжүүлж, хаваржуулах талаар сум, бусад аймаг хооронд 09 дугаар сарын 20-ны дотор гэрээ байгуулсугай.

4. Аймаг, сумын өвс, тэжээлийн нөөцийг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 322 дугаар тогтоолын дагуу бүрдүүлэх арга хэмжээ авсугай.

116

5. Хадлан, гар тэжээл бэлтгэх сарын аян зарлаж идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг шалгаруулж мал аж ахуйг эрсдлээс хамгаалах уламжлалт аргыг сэргээж ажилласугай.

6. Сумын төв суурин газруудын өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөгөө боловсруулж, аж ахуйн нэгж байгууллагуудад ажлын хэсэг байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээ авсугай.

7. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдад ажлын хэсэг томилон ажиллуулж, ХХААХҮСайдын болон аймгийн Засаг даргын 2016 оны 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч дүнг 10 дугаар сарын 20-ны дотор ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

8.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 75 Номгон

Тогтоол хэрэгжүүлэх ажлыг
эрчимжүүлэх тухай

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын мэдээллийг хэлэлцээд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал-д даалгах нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 113 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, явц нь удаашралтай байгаа шалтгааныг судалж, тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, эзэмшүүлсэн газрын нөхөн төлбөрийг 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшиж буй газартаа зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын жагсаалтыг гаргаж, санал дүгнэлтийн хамт аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд 2017 оны 1 дүгээр улиралд багтааж танилцуулсугай.

3. Тогтоолын биелэлтийг заасан хугацаанд үе шаттайгаар танилцуулахыг тус тус даалгасугай.

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

116007

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 76 Номгон

Гамшгийн хохиролыг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай

Аймгийн төв Баянхонгор сумын нутаг дэвсгэрт 2016 оны 08 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд хүчтэй аадар бороо орсоны улмаас 1,2,3,5,6,7,9 дүгээр баг, Есөн-Эрдэнэ зах, аймгийн Цэвэр усны байгууламжийн үерээс хамгаалах далан, орон сууцны зарим барилгууд, Баянхонгор их дэлгүүр, Тэмүүжин театр, Баянхонгор, Эрдэнэцогт, Өлзийт, Шаргалжуут чиглэлийн өндөр хүчдэлийн шугам үерийн гамшигт өртөж урдчилсан байдлаар иргэд, аж ахуй нэгж байгууллага, инженерийн байгууламжуудад нийт 271,207,590 төгрөгийн хохирол учирсан байна.

Үүссэн нөхцөл байдал, тухайн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар аймгийн Онцгой байдлын газраас танилцуулсан мэдээллийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал-д даалгах нь:

1. Баянхонгор сумын Цэвэр усны байгууламжийн эх үүсвэрийг хамгаалах 630 м далан үерт эвдэгдсэнийг хүйтний улирал эхлэхээс өмнө буюу 10 дугаар сарын 01-ний дотор сэргээн засварлаж Баянхонгор сумын иргэдийн ундны усны эх үүсвэрийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг хангаж холбогдох зардлын асуудлыг шийдвэрлсүгэй.

2. Баянхонгор сумын хэмжээнд үер уснаас хамгаалах далан, ус зайлуулах инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу шинээр барьж байгуулах ажлыг үе шаттайгаар эхлүүлэх, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсүгэй.

116000

3. Аймгийн Онцгой байдлын газрын хүн хүч, орон тоог нэмэгдүүлэх, техник хэрэгслийг сайжруулах асуудлыг Монгол улсын Засгийн газар, Онцгой байдлын ерөнхий газарт тавьж шийдвэрлүүлэх, гамшигтай тэмцэх чадавхийг сайжруулсугай.

4. Аливаа гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, дуудлага мэдээлэл өгөх үед шуурхай ажиллах, албан хаагчдын ёс зүйд анхаарч, хийсэн ажлын тайлан мэдээг ард иргэдэд сурталчлах, гамшгийн үед хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцсугай.

5. Үер усны гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны зардлуудыг гамшгаас хамгаалах сангаас гаргаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд энэ оны IY улиралд багтаан танилцуулсугай.

6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 97 Номгон

Ажлын албаны бүтэц, орон тоог
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн хавсралтаар батлалсугай.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны бүтэц, орон тоог шинээр баталсантай холбогдуулан ажилтнуудын ажлын уялдаа, ачааллыг жигдрүүлж, ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн ХурлынТэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 92 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

D;2016-tushaal2016

116015

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 78 Номгон

Тэргүүлэгчдийн нарийн бичгийн
даргыг чөлөөлөх, томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалт, Авилгатай тэмцэх газрын 2016 оны 09 дүгээр сарын 16-ны 01/6180 албан тоотыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дагвын Юндэнбазарыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас нь 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Сэдхүүгийн Үнэнбуянг томилсугай.

3. С.Үнэнбуянд ТЗ-11 ангиллын 5 шатлалаар үндсэн цалинг тогтоож, хууль журмын дагуу холбогдох нэмэгдлийг бодож олгохыг няптлан бодогч /Г.Ариунбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

D;2016-togtool2016

116043